



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар A/155

Бор-Өндөр сум

**Технологийн усны шугамын трасс
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Бор-Өндөр сумын Хүйх 5 дугаар багийн нутаг дэвсгэр, Үйлдвэр-117 тоот хаягт байрлах “Жи Зэт Эс Вай майнинг ” ГХОХХК-ийн хүсэлтийн дагуу тус компанийн баяжуулах үйлдвэрийн технологийн усыг газар доогуур татах шугамын трассыг нэгдүгээр хавсралтад зааснаар баталсугай.
2. Батлагдсан зурвас газарт газар эзэмшил, өмчлөл, ашиглалт давхцуулж олгохгүй байх, шугамыг Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлжүүлэхийг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль хамгаалагч (Б.Баярбаясгалан)-д даалгасугай.
4. Технологийн ус татах шугамыг батлагдсан норм, дүрмийн дагуу хийж гүйцэтгэхийг “Жи Зэт Эс Вай майнинг” ХХК-ийн Гүйцэтгэх захирал (А.Батхолбоо)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ГАЛБАДРАХ





Сумын Засаг даргын 2025 оны 6 дугаар сарын ...-ны
өдрийн 13 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь "Жи Зэт Эс Вай майнинг" ГХОХХК-ийн

Технологийн ус дамжуулах шугамын трасс

1	Шугамын эхлэл, төгсгөл	Эргэлтийн цэгийн координат		Шугамын урт /м/
		X	Y	
1.	1-2	5123716.720	381031.284	398
2.	2-3	5123323.239	381092.138	965
3.	3-4	5122693.529	381825.035	1037
4.	4-5	5122374.117	382810.213	
Нийт				2399,6м